



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/769

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн сувилагч Ц.Оюундуламыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Ц.Оюундуламд 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал /П.Улаанхүү/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

